

**ЗАХИРГАА, УДИРДЛАГЫН ГАЗРЫН ДОТООД ХЯНАЛТ ХАРИУЦСАН  
МЭРГЭЖИЛТЭН ГАНЗОРИГИЙН ТҮМЭНДЭЛГЭРИЙН 2025 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН  
ХАГАС ЖИЛИЙН ТАЙЛАН**

**Нэг.Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт**

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Хүрэх түвшин			Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Эхний хагас жил		
1	2	3	4	5	5	7	8
<b>Зорилт 1. "Байгууллага, албан хаагчийн үйл ажиллагаатай холбогдох гомдол, мэдээллийг шалгаж шийдвэрлүүлэх, үйл ажиллагааны болон объектын аюулгүй байдлыг хангах, гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулж, хэрэгжүүлэх" зорилтын хүрээнд</b>							
10.	Арга хэмжээ 1.1 Байгууллагын алба хаагчийн үйл ажиллагаатай холбоотой иргэн, байгууллага, албан хаагчийн ирүүлсэн үндэслэл бүхий гомдол, мэдээлэлд байгууллагын даргын шийдвэрээр хяналт, шалгалт явуулах	- Гүйцэтгэлийн хувь	-	50	Тайлангийн хугацаанд иргэн, төрийн байгууллага, албан тушаалтнаас ирүүлсэн 19 албан бичиг, 3 өргөдлийг хүлээн авч холбогдох ажиллагааг хийж хариуг хугацаанд нь хүргүүлэн, байгууллагын даргын 2021 оны А/233 дугаар тушаалаар баталсан "Гадаадын иргэн, харьяатын газрын дотоод хяналт шалгалт зохион байгуулах журам"-ын дагуу дотоод хяналт шалгалтыг албан хаагчид холбогдуулан төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг явуулснаас холбогдох хуулийн байгууллагад 2, Төрийн албаны тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1.1-д заасан "өөрт ганцаарчилсан хэлбэрээр сануулах" сахилгын шийтгэл 1 албан хаагчид, 48.1.2-д заасан "нийт ажилтанд зарлах хэлбэрээр нээлттэй сануулах" сахилгын шийтгэл 3 албан хаагчид, 48.1.3-д заасан "албан тушаалын цалингийн хэмжээг 3 сар хүртэл хугацаагаар 20 хувиар бууруулах" сахилгын шийтгэл 2 албан хаагчид тус тус ногдуулж, 3 албан хаагчийн ёс зүйн хариуцлагын талон цоолсон.	03-06	
11.	Арга хэмжээ 1.2 Байгууллагын үйл ажиллагаатай хамаарал бүхий олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр тараагдсан мэдээлэлд хяналт шалгалт хийх	- Гүйцэтгэлийн хувь	-	50	Байгууллага, алба хаагчтай холбоотойгоор олон нийтийн цахим сүлжээнд тараагдсан мэдээлэлд тогтмол хяналт тавьж ажилласан бөгөөд холбогдох хууль тогтоомж зерчсөн тухай алба хаагчийн талаарх мэдээлэл олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр тараагдаагүй байна.	03-06	

12.	Арга хэмжээ 1.3 Төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах	- Гүйцэтгэлийн хувь	-	50	<p>Гадаадын иргэн, харьяатын газрын дотоод хяналт шалгалтын 2025 онд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг санал өгч байгууллагын даргаар батлуулсан.</p> <p>“Гадаадын иргэн, харьяатын газрын дотоод хяналт шалгалт зохион байгуулах журам”-ын дагуу дотоод хяналт шалгалтыг 11 албан хаагчид холбогдуулан 9 төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг явуулснаас холбогдох хуулийн байгууллагад 2, Төрийн албаны тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1.1-д заасан “өөрт ганцаарчилсан хэлбэрээр сануулах” сахилгын шийтгэл 1 албан хаагчид, 48.1.2-д заасан “нийт ажилтанд зарлах хэлбэрээр нээлттэй сануулах” сахилгын шийтгэл 3 албан хаагчид, 48.1.3-д заасан “албан тушаалын цалингийн хэмжээг 3 сар хуртэл хугацаагаар 20 хувиар бууруулах” сахилгын шийтгэл 2 албан хаагчид тус тус ногдуулж, 3 албан хаагчийн ёс зүйн хариуцлагын талон цоопсон.</p>	03-06	
13.	Арга хэмжээ 1.4 Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын төлөвлөгөөг хэрэгжилтийг хангах	- Төлөвлөгөөг батлуулсан огноо - Хэрэгжилтийн хувь	-	50	<p>2025 оны 01 дүгээр сарын 21-ний өдөр Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын төлөвлөгөөг боловсруулж байгууллагын даргаар батлуулсан. Төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах хүрээнд Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлөөс зохион байгуулсан “Хүн худалдаалах гэмт хэргийн талаарх”, Цагдаагийн ерөнхий газрын Хар тамхитай тэмцэх газраас зохион байгуулсан “Мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус хэрэглээ” сургалтуудад тус тус албан хаагчдын хамт хамрагдсан. Төвийн алба хаагчид болон орон нутаг дахь нэгжийн дарга нараас гадаад улсад албан болох хувийн ажлаар зорчсон тохиолдолд “гадаад улсад зорчих алба хаагчийн баталгааг” бичүүлэн авч бүртгэл хөтлөн ажиллаж байна. /Нийт 25 алба хаагчаас авсан/</p>	03-06	
14.	Арга хэмжээ 1.5 Байгууллагын үйл ажиллагааны болон	- Гүйцэтгэлийн хувь	-	50	Дотоодын цэргийн 05 дугаар ангиас байгууллага дээр харуулын үүрэг гүйцэтгэж байгаа алба	03-06	

	объектын аюулгүй байдлыг хангах ажлыг зохион байгуулж хяналт тавьж ажиллах			хаагчдын объектын аюулгүй байдлыг хангахад камерын хяналтаар болон биет байдлаар хяналт тавьж Гадаадын иргэн, харьятын газрын төв байрны аюулгүй байдлыг хангах гэрээний хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Цагаан сар, нийтээр тэмдэглэх баярын өдруудэд байгууллагын үйл ажиллагаа, харилцаа холбооны хэвийн байдлыг хангах зорилгоор байгууллагын даргын 2025 оны 02 дугаар сарын 24-ны өдрийн А/98 дугаартай тушаалын төсөл боловсруулан батлуулж тушаалын хэрэгжилтийг хангаж ажилласан. Нийтээр тэмдэглэх баярын өдрийг тохиолдуулан Монгол Улсад олон нийтээрээ дагаж мөрдэж байгаа хууль тогтоомж, Улсын онц чухал объектод тогтоосон журмыг сахин биелүүлэх, объектын аюулгүй байдал, хэвийн үйл ажиллагааг хангах, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор 02 дугаар сарын 21-ны өдрийн 8 заалт бүхий зөвлөмжийг төв орон нутгийн газар, хэлтсийн дарга наарт хүргүүлж, хэрэгжилтэд хяналт тавин ажилласан. "Гадаадын иргэн, харьятын газрын төв байранд хүн, ачаа, тээврийн хэрэгслийг шалган нэвтрүүлэх журам"-д заасны дагуу ажлын байранд ажиллах алба хаагч наарт зөвшөөрлийн 18 хуудаст тэмдэглэл үйлдэн, давхардсан тоогоор 76 алба хаагчийн нэвтрэх зөвшөөрлийг байгууллагын харуулд хүлээлгэн егсэн.	
--	--	--	--	--	--

Зорилт 2. "Байгууллагын соёл, дэг журмыг сахиулах, албан хаагчийн сахилга,  
Ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, ажлын цаг ашиглалтад хяналт тавих" зорилтын хурээнд

15.	Арга хэмжээ 2.1 Гамшгаас хамгаалах хууль тогтоомжийн хэрэгжилтийг зохион байгуулж ажиллах	- Зохион байгуулалтын ажлын хувь	-	50	Гамшгаас хамгаалах төлөвлөгөөг шинээр боловсруулж төвийн болон боомт орон нутгийн газар хэлтсүүдэд хүргүүлсэн. Гамшгаас хамгаалах хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж, болзошгүй аюул, гамшгаас ослоос хамгаалах ажлын хурээнд	03-06	
-----	---	----------------------------------	---	----	--	-------	--

					байгууллагын төв болон Б байр, тавиулан зэргийг үер усны аюулаас хамгаалах зорилгоор Санхүү, хангарт үйлчилгээний газрын алба хаагч наортай тогтмол үзлэг шалгалт хийж тавиуланд орсон усыг соруулан ажилласан. 2025 оны 03 дугаар сарын 27-ний өдөр Хан-Уул дүүргийн засаг даргаас ирүүлсэн албан бичгийн дагуу гамшигаас хамгаалах хууль хэрэгжилтийн хүрээнд албан хаагчдын бэлэн байдлыг хангуулж 16 цагт төвийн байрны 80 албан хаагчийг хувцас, аранз зэргийн бэлэн байдлын хангуулж цуглах цэгт жагсааж үр дунг илтгэх хуудсаар Захиргаа, удирдлагын газрын даргад танилцуулж хувийг 21 дүгээр хорооны засаг даргад хүргүүлсэн. Байгууллагын даргын 2025 оны 01-02/27 удирдамжийн дагуу Гамшигаас хамгаалах сургалтын төв 116 дугаар ангитай хамтран 05 дугаар сарын 14-ны өдөр "Гамшиг эрсдэлийн үед авах арга хэмжээ" сэдэвт сургалтыг зохион байгуулсан сургалтад төвийн нэгжийн албан хаагчдын хамт хамрагдсан. 2025 оны 05 дугаар сарын 20-ний өдрийн 2/89 дугаартай Монгол цэргийн холбооноос ирүүлсэн албан бичгийн дагуу 05 дугаар сарын 23-ний өдөр Монгол цэргийн холбоонд зохион байгуулгасан "Үндэсний сэрен тэсвэрлэх чадавх, орон нутгийн хамгаалалтын тогтолцоог бэхжүүлэхэд оролцогч байгууллагуудын бодлого, зохицуулалт, үйл ажиллагааны өнөөгийн байдалд дүгнэлт хийх" сэдэвт хурал, зөвлөгөөнд хамрагдсан.	
16.	Арга хэмжээ 2.2 Алба хаагчдын дүрэмт хувцас өмсөх, хэрэглэх журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажилласан байна.	- Хэрэгжилтийн хувь	-	50	Байгууллагын даргын баталсан 2021 оны 04 дүгээр сарын 28-ний өдрийн А/82 дугаартай "Гадаадын иргэн, харьяатын газрын албан хаагчдын дүрэмт хувцас өмсөх, хэрэглэх журам"-д заасны дагуу албан хаагчдын дүрэмт хувцас өмссөн байдалд өдөр бүр биечлэн хяналт тавьж зөрчилтэй 13 албан хаагчдын зөрчлийг засуулсан.	03-06
17.	Арга хэмжээ 2.3 Байгууллагын соёл, дэг журмыг сахиулах, нэгжийн дарга нар болон албан	- Байгууллагын даргад танилцуулсан	4	2	Байгууллагын соёл, дэг журмыг сахиулах, нэгжийн дарга нар болон албан хаагчдын ажлын цаг ашиглалтад 2024 оны 12 дугаар сарын 20, 2025 оны	03-06

	хаагчдын ажлын цаг ашиглалтад өдөр тутам хяналт тавьж, улиралд 1 удаа байгууллагын даргад илтгэх хуудсаар танилцуулах.	илтгэх хуудасны огноо, дугаар			03 дугаар сарын 19, 05 дугаар сарын 12-ний өдрүүдэд биечлэн хяналт тавьж үр дүнг захиргаа, удирдлагын газрын даргад 01-02/156, 01-02/18, 01-02/44 дугаартай илтгэх хуудсуудаар тус тус танилцуулсан. Терийн байгууллагуудын дотоод үйл ажиллагааны удирдлагын нэгдсэн системийн (егр) цаг бүртгэлийн цэсэд албан хаагчдын ажлын цаг бүртгэгдсэн байдалд өдөр тутамд хяналт тавьж, орон нутаг дахь нэгжийн дарга нарын цаг ашиглалтын хяналтын камераар бүртгэж нэгжийн даргад тухай бүр танилцуулж ажилласан.		
18.	Арга хэмжээ 2.4 Байгууллагын үйл ажиллагаа, үйлчилгээ, хууль тогтоомжтой холбоотой мэдээ, мэдээллийг олон нийтийн цахим сүлжээнд түгээх.	- Түгээлтийн тоо	-	30	2025 оны хагас жилийн байдлаар байгууллагын үйл ажиллагаа, үйлчилгээ, хууль тогтоомжтой холбоотой мэдээ, мэдээллийг олон нийтийн цахим сүлжээнд 91 удаа түгээсэн байна.	03-06	

#### Нэмэлт үүрэг даалгаврын биелэлт

Д/д	Үүрэг даалгавар	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
10.	Боомт орон нутаг дахь газар хэлтэс, хилийн боомтуудыг камерын хяналтанд авч байгууллагын төвд оруулах ажлыг зохион байгуулан АЗБХГ, Зүүн бүс дэх, Өмнөд бүс дэх газар, Баян-Өлгий хэлтсийн камерын хяналтад холбогдон хэвийн ажиллаж байна. /Хойд, Баруун, Дорноговь аймаг дахь газар /ыг холбооор ажиллаж байна. Боомт орон нутгийн газар, хэлтсүүдэд камержуулах чиглэлээр нийт 4 удаагийн дотоод албан бичиг, ажлын чиглэл, зөвлөмж хүргүүлсэн болно.	Хэрэгжилтийн хувь	-	-	Боомт орон нутаг дахь газар хэлтэс, хилийн боомтуудыг камерын хяналтанд авч байгууллагын төвд оруулах ажлыг зохион байгуулан АЗБХГ, Зүүн бүс дэх, Өмнөд бүс дэх газар, Баян-Өлгий хэлтсийн камерын хяналтад холбогдон хэвийн ажиллаж байна. /Хойд, Баруун, Дорноговь аймаг дахь газар /ыг холбооор ажиллаж байна. Боомт орон нутгийн газар, хэлтсүүдэд камержуулах чиглэлээр нийт 4 удаагийн дотоод албан бичиг, ажлын чиглэл, зөвлөмж хүргүүлсэн болно.	03-06	
11.	Байгууллагын хөдөлмөрийн дотоод журам, Мэдээллийн технологийн үйл ажиллагааны журмын хэрэгжилтийг хангулан ажиллах	Хэрэгжилтийн хувь	-	-	Байгууллагын даргын 2025 оны 01 дүгээр сарын 14-ний өдрийн шалгалт явуулах тухай 01-02/05 дугаар удирдамжийн хүрээнд байгууллагын төв байрны өрөөнүүдийн хаалганы лац, албан хаагчдын албан хэрэгцээнд ашиглаж байгаа техник, хэрэгслийн аюулгүй байдалд шалгалт явуулан илтгэх хуудсаар байгууллагын даргад танилцуулсан. 2025.05.05-ний өдөр төв болон	03-06	

					боомт орон нутгийн газар хэлтсүүдэд 03 дугаартай зөвлөмж <b>хургуулсэн</b> .		
12.	Байгууллагын системийн аварга шалгаруулах 4 төрөлт тэмцээнд оролцох	Хэрэгжилтийн хувь	-	-	Байгууллагын системийн аварга шалгаруулах 4 төрөлт тэмцээнд Гар бөмбөгийн төрөлд Захиргаа, удирдлагын газрын баг тамирчдын хамт амжилттай оролцсон.	03-06	

**Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээ**

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				Эхлэх, дуусах хугацаа	Биелэлтийн хувь	
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)				
1	2	3	4	5	7	8			
<b>ДӨРӨВ."ТӨРИЙН АЛБАНЫ ТУХАЙ ХУУЛЬ, САЛБАРЫН ХУУЛЬ, ДАГАЛДАН ГАРСАН ХУУЛЬ ТОГТООМЖИД ЗААСАН МЭДЛЭГ ЧАДВАРЫГ ЭЗЭМШИХ, ТАСРАЛТГҮЙ ХӨГЖҮҮЛЭХ" ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД</b>									
13.	Арга хэмжээ 1.1 Удирдлагын академийн Ёс зүй 1, 2, 3 түвшний цахим сургалтад хамрагдах.	сертификатын дугаар	-	1	3, 4 дүгээр улиралд хамрагдахаар төлөвлөн ажиллаж байна.		03-06		
14.	Арга хэмжээ 1.2 Монгол бичгийн 1, 2, 3 түвшний сургалтад хамрагдах	- Сургалтад хамрагдсан эсэх	-	-	Удирдлагын академиас зохион байгуулдаг монгол бичгийн 1, 2-р түвшний сургалтад онлайнаар хамрагдаж шалгалт өгч тэнцсэн.		03-06		
15.	Арга хэмжээ 1.3 Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах, хуулийг хэрэгжүүлэх суурь мэдлэг олгох, Худалдан авах ажиллагааны мэргэшүүлэх А3 сургалтад хамрагдах	- Сургалтад хамрагдсан эсэх	-	-	Худалдан авах ажиллагааны мэргэшүүлэх А3 сургалтад албан хаагчдын хамт хамрагдаж, шалгалт өгч тэнцэж, сертификат авсан. Гэрчилгээний дугаар: /2025/2578/		03-06		

ТАЙЛАН ГАРГАСАН:

ДОТООД ХЯНАЛТ,  
ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН

Г.ТҮМЭНДЭЛГЭР

2025.06.09

ХЯНАН БАТАЛГААЖУУЛСАН:  
ЗАХИРГАА, УДИРДЛАГЫН ГАЗРЫН  
ДАРГА

И.БААТАРХҮҮ

2025.06.09